



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/26/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2026 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Ж.Угтахбаяр Утас: 70593113 Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

0

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	/төгрөгөөр/.....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	/төгрөгөөр/5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	/төгрөгөөр/.....6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	/төгрөгөөр/7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
3.2 Зөвлөмж.....	14
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.13

№

27

танай

-ны №

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.ГАНЧИМЭГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад төсвөөс олгох санхүүжилтийг 55.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь өмнөх оноос цалин хөлс болон нэмэгдэл урамшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардлууд өссөнтэй холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй. Харин тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ нь 608.3 сая төгрөгийн үнэ төлбөргүй орлого хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй

4826050091

болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 бүлэг, 6 зорилт, 61 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 82.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,803,370.00	4,253,370.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,803,370.00	4,253,370.00
31210	Төгрөг	6,803,370.00	4,253,370.00
31218	Ахмадын сангийн харилцах	6,803,370.00	4,253,370.00
33	АВЛАГА	224,649.23	629,078.95
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	224,649.23	224,649.23
33101	Цалингийн авлага	224,649.23	224,649.23
33500	Бусад авлага		404,429.72
33510	Байгууллагаас авах авлага		404,429.72
35	БАРАА МАТЕРИАЛ	185,693,917.00	175,914,103.00
35100	Түүхий эд материал	2,660,400.00	
35110	Тусгай зориулалттай материал	2,660,400.00	
35400	Хангамжийн материал	175,758,517.00	168,639,103.00
35410	Бичиг хэргийн материал	3,394,298.00	2,462,298.00
35420	Аж ахуйн материал	169,975,619.00	162,407,405.00
35450	Барилгын засварын материал	2,388,600.00	3,769,400.00
35600	Мал амьтад	7,275,000.00	7,275,000.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	192,721,936.23	180,796,551.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,869,531,399.85	5,043,496,183.85
39200	Биет хөрөнгө	4,696,956,394.85	4,871,878,503.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,440,817,274.07	5,538,896,880.07
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(1,317,695,641.10)	(1,627,675,451.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	241,782,158.55	511,561,674.68
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(86,440,477.57)	(91,279,961.87)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	346,870,964.93	387,619,972.93
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(195,721,251.34)	(97,060,921.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	199,252,444.00	174,038,944.00
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(95,162,076.69)	(87,475,632.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	163,253,000.00	163,253,000.00
39300	Биет бус хөрөнгө	172,575,005.00	171,617,679.92
39301	Програм хангамж	5,136,625.00	5,136,625.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(350,000.00)	(1,307,325.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	167,788,380.00	167,788,380.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	4,869,531,399.85	5,043,496,183.85
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	5,062,253,336.08	5,224,292,735.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		18,056,035.00
41300	Өглөг		18,056,035.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		18,056,035.00
413201	Бичиг хэргийн өглөг		2,595,600.00
413205	Тээвэр, шатахууны өглөг		10,158,085.00
413210	Урсгал засварын зардлын тооцоо		3,541,550.00
413213	Бусад зардлын өглөг		1,760,800.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)		18,056,035.00
51	Засгийн газрын хувь оролцоо	5,062,253,336.08	5,206,236,700.80
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	892,803,037.00	892,803,037.00
511002	Засгийн газрын оруулсан капитал орон нутгийн сан	892,803,037.00	892,803,037.00
51200	Хуримтлагдсан үр дүн	4,169,450,299.08	4,313,433,663.80
51210	Өмнөх үеийн үр дүн	4,169,450,299.08	4,169,160,139.08
51220	Тайлант үеийн үр дүн		144,273,524.72
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	5,062,253,336.08	5,206,236,700.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	5,062,253,336.08	5,224,292,735.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	993,114,157.93	1,033,159,732.72
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,244,457.93	64,624,332.72
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,200,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	30,193,958.00	24,083,746.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,850,499.93	40,540,586.72
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	912,869,700.00	968,535,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	912,869,700.00	968,535,400.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	771,416,692.93	577,887,583.13
1200	Нийтлэг татварын бус орлого	771,416,692.93	577,887,583.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,000,000.00	1,196,621.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	4,000,000.00	1,196,621.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	746,478,151.93	576,690,962.13
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	20,938,541.00	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,764,530,850.86	1,611,047,315.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,235,557,576.48	1,465,130,125.18
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,120,278,558.80	1,345,844,189.38
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	470,222,736.65	660,015,070.53
210101	Үндсэн цалин	299,955,446.09	377,037,377.54
210102	Нэмэгдэл	141,250,017.56	256,965,564.99
210104	Урамшуулал	29,017,273.00	26,012,128.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,064,516.06	80,273,348.37
210201	Тэтгэврийн даатгал	35,757,811.96	54,970,711.28
210202	Тэтгэмжийн даатгал	5,034,510.19	6,520,430.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,517,305.44	3,260,215.31
210204	Ажилгүйдлийн даатгал	2,351,017.60	3,081,425.53
210205	Эрүүл мэндийн даатгал	9,403,870.87	12,440,565.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,622,277.21	47,340,905.70
210301	Гэрэл, цахилгаан	18,535,602.15	20,316,547.70
210302	Түлш, халаалт	30,586,675.06	27,024,358.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	68,445,331.00	48,805,844.00
210401	Бичиг хэрэг	1,140,400.00	3,995,600.00
210402	Тээвэр, шатахуун	45,936,400.00	25,614,125.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	293,500.00	153,605.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,654,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	106,000.00	11,665,140.00
210408	Бараа материал актласны зардал	19,315,031.00	6,377,374.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,382,300.00	8,771,250.00
210604	Урсгал засвар	12,382,300.00	8,771,250.00
2107	Томилолт, зочны зардал	14,636,000.00	4,420,000.00
210702	Дотоод албан томилолт	14,636,000.00	4,420,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,909,084.20	44,629,058.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,921,924.00	42,550,016.00
210803	Даатгалын үйлчилгээ	212,250.00	1,022,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	984,182.20	446,201.60
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,000.00	210,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		400,000.00
210807	Газрын төлбөр	1,669,728.00	241.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	421,996,313.68	451,588,712.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,541,793.40	47,379,800.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	2,750,000.00	1,626,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	330,704,520.28	402,582,512.18

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,279,017.68	119,285,935.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,525,583.28	27,720,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,000,000.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		27,720,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,916,583.28	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	15,609,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	87,753,434.40	91,565,935.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,405,270.68	78,359,172.88
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	12,348,163.72	13,206,762.92
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,235,557,576.48	1,465,130,125.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	528,973,274.38	145,917,190.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	14,115,491.00	1,643,665.95
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	14,115,491.00	1,643,665.95
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	14,115,491.00	1,643,665.95
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	514,857,783.38	144,273,524.72

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	993,114,157.93	1,033,159,732.72
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,244,457.93	64,624,332.72
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,200,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	30,193,958.00	24,083,746.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,850,499.93	40,540,586.72
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	912,869,700.00	968,535,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	912,869,700.00	968,535,400.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	4,000,000.00	1,196,621.00
1200	Нийтлэг татварын бус орлого	4,000,000.00	1,196,621.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,000,000.00	1,196,621.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	4,000,000.00	1,196,621.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	997,114,157.93	1,034,356,353.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	901,014,163.93	1,035,406,353.72
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	785,735,146.25	916,120,417.92
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	468,671,940.00	660,217,227.66
210101	Үндсэн цалин	298,404,649.44	343,090,204.57
210102	Нэмэгдэл	141,250,017.56	282,605,106.28
210104	Урамшуулал	29,017,273.00	30,542,849.66
210105	Гэрээт ажлын цалин		3,979,067.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,839,961.94	80,475,620.96
210201	Тэтгэврийн даатгал	37,533,257.84	54,076,223.81
210202	Тэтгэмжийн даатгал	5,034,510.19	7,572,523.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,517,305.44	3,256,117.30
210204	Ажилгүйдлийн даатгал	2,351,017.60	3,091,178.52
210205	Эрүүл мэндийн даатгал	9,403,870.87	12,479,577.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,797,388.71	47,631,065.70
210301	Гэрэл, цахилгаан	18,535,602.15	20,316,547.70
210302	Түлш, халаалт	33,761,786.56	27,314,518.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	42,892,650.00	13,528,635.00
210401	Бичиг хэрэг	3,285,000.00	468,000.00
210402	Тээвэр, шатахуун	35,708,100.00	11,779,530.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	293,500.00	153,605.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,654,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,952,050.00	127,500.00
2105	Нормативт зардал	1,100,000.00	1,027,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,100,000.00	1,027,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,053,000.00	12,000,000.00
210604	Урсгал засвар	15,053,000.00	12,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	14,636,000.00	4,420,000.00
210702	Дотоод албан томилолт	14,636,000.00	4,420,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,293,738.20	44,629,058.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,306,578.00	42,550,016.00
210803	Даатгалын үйлчилгээ	212,250.00	1,022,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	984,182.20	446,201.60
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,000.00	210,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		400,000.00
210807	Газрын төлбөр	1,669,728.00	241.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,450,467.40	52,191,810.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,700,467.40	50,565,410.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	2,750,000.00	1,626,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,279,017.68	119,285,935.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,525,583.28	27,720,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,000,000.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		27,720,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,916,583.28	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	15,609,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	87,753,434.40	91,565,935.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,405,270.68	78,359,172.88
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	12,348,163.72	13,206,762.92
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	901,014,163.93	1,035,406,353.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	96,099,994.00	(1,050,000.00)
14	ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	98,900,000.00	1,500,000.00
223	БУСАД ХӨРӨНГӨ	98,900,000.00	
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	98,900,000.00	
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		1,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		1,500,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	98,900,000.00	1,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(98,900,000.00)	(1,500,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	(2,800,006.00)	(2,550,000.00)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,603,376.00	6,803,370.00
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,803,370.00	4,253,370.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
-----	----------	----------------------------------	----------------------	--

1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,803,037.00	4,169,450,299.08	5,062,253,336.08
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	892,803,037.00	4,169,450,299.08	5,062,253,336.08
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,803,037.00	4,169,450,299.08	5,062,253,336.08
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	892,803,037.00	4,169,450,299.08	5,062,253,336.08
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		(290,160.00)	(290,160.00)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	892,803,037.00	4,169,160,139.08	5,061,963,176.08
17	Өмчид гарсан өөрчлөлт			
18	Зарласан ноогдол ашиг			
19	Тайлант үеийн үр дүн		144,273,524.72	144,273,524.72
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,803,037.00	4,313,433,663.80	5,206,236,700.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
12	Татварын бүс орлого	985,903,200.00	891,372,848.12	94,530,351.88
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/		1,196,621.00	(1,196,621.00)
300001	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		54,107,600.00	(54,107,600.00)
12200	Тусламжийн орлого	985,903,200.00	836,068,627.12	149,834,572.88
122005	Төсвөөс санхүүжих	985,903,200.00	836,068,627.12	149,834,572.88
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	985,903,200.00	891,372,848.12	94,530,351.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	985,903,200.00	891,372,848.12	94,530,351.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	948,033,200.00	863,652,848.12	84,380,351.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	680,293,500.00	660,217,227.66	20,076,272.34
210101	Үндсэн цалин	340,742,300.00	343,090,204.57	(2,347,904.57)
210102	Нэмэгдэл	275,001,700.00	282,605,106.28	(7,603,406.28)
210104	Урамшуулал	38,364,900.00	30,542,849.66	7,822,050.34
210105	Гэрээт ажлын хөлс	26,184,600.00	3,979,067.15	22,205,532.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,398,400.00	80,475,620.96	922,779.04
210201	Тэтгэврийн даатгал	53,688,700.00	54,076,223.81	(387,523.81)
210202	Тэтгэмжийн даатгал	6,927,500.00	7,572,523.81	(645,023.81)
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,463,700.00	3,256,117.30	207,582.70
210204	Ажилгүйдлийн даатгал	3,463,700.00	3,091,178.52	372,521.48
210205	Эрүүл мэндийн даатгал	13,854,800.00	12,479,577.52	1,375,222.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,192,800.00	33,633,891.90	7,558,908.10
210301	Гэрэл, цахилгаан	6,760,000.00	6,319,373.90	440,626.10
210302	Түлш, халаалт	31,232,800.00	27,314,518.00	3,918,282.00
210303	Цэвэр, бохир ус	3,200,000.00		3,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,000,900.00	12,747,105.00	19,253,795.00
210401	Бичиг хэрэг	3,540,000.00	468,000.00	3,072,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,625,900.00	10,998,000.00	5,627,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,347,000.00	153,605.00	4,193,395.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,188,000.00	1,000,000.00	3,188,000.00
210406	Бага үнэгэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,300,000.00	127,500.00	3,172,500.00
2105	Нормативт зардал	1,027,000.00	1,027,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,027,000.00	1,027,000.00	

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,000,000.00	13,500,000.00	500,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	2,000,000.00	1,500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	12,000,000.00	
2107	Томилолт, зочны зардал	5,600,000.00	4,420,000.00	1,180,000.00
210702	Дотоод албан томилолт	5,600,000.00	4,420,000.00	1,180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	40,800,600.00	21,434,842.60	19,365,757.40
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	36,866,000.00	19,355,800.00	17,510,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,022,600.00	1,022,600.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	536,000.00	446,201.60	89,798.40
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	226,000.00	210,000.00	16,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	605,000.00	400,000.00	205,000.00
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	1,545,000.00	241.00	1,544,759.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,720,000.00	36,197,160.00	15,522,840.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,520,000.00	34,570,760.00	14,949,240.00
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	2,200,000.00	1,626,400.00	573,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,870,000.00	27,720,000.00	10,150,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,720,000.00	27,720,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,150,000.00		10,150,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	64,624,332.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,624,332.72
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,417,569.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,997,173.80
210301	Гэрэл, цахилгаан	13,997,173.80
2104	Хангамж, бараа материалын зардал	781,530.00
210402	Тээвэр, шатахуун	781,530.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,194,216.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,194,216.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,444,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,444,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,206,762.92
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,206,762.92
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	13,206,762.92
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	64,624,332.72
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	64,624,332.72
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	64,624,332.72
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	24,083,746.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	40,540,586.72

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,266.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 1,740.8 мянган төгрөгийн 2 зөрчлийг аудитын явцад залруулан, 3,931.6 мянган төгрөгийн 3 зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага, 4,593.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Залруулсан алдаа:

1. Өмнөх оны 290.2 мянган төгрөгийн халаалтын өглөгийг тайлант оны зардлаар илүү тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т (*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*) заасныг;
2. Өмчийн өөрчлөлтийн тайлангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансыг 1,450.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т (*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*) заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад бүрэн залруулсан..

Залруулагдаагүй алдаа:

3.1 Төлбөрийн акт

1. Төсвийн хөрөнгөөр албан хаагчдад 2,524.5 мянган төгрөгийн хувцас худалдан авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1-т (*Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно*) заасныг;
2. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн орлогоос орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 40 хувь буюу 2,069.4 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т (*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны "Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар"-ын 1.8-д (*Түрээсийн орлогоос орон нутгийн төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгийн 40 хувиар тооцож түрээслэгч төсөвт төвлөрүүлнэ*) заасныг тус тус зөрчсөн.

3.2 Албан шаардлага

1. Санхүүгийн тайлан дахь насжилт өндөртэй 224.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*), 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*) заасныг;
2. Төсвийн хөрөнгөөр албан хаагчдад 1,027.0 мянган төгрөгийн хувцас худалдан авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1-т (*Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно*) заасныг;
3. Төрийн ажил үйлчилгээг олон нийтэд мэдээлэх зорилгоор видео, фото мэдээлэл бэлтгүүлэн, 2,680.0 мянган төгрөгийн төсвийн төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-т (*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*), 15.1.4-т (*Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг*

сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх) заасныг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 4,818.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 9,832.8 мянган төгрөгөөр бага тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх оны халаалтын өглөгийг тайлант оны зардлаар илүү тайлагнасан.	1	290.2			1	290.2	1	290.2		
Өмчийн өөрчлөлтийн тайлангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансыг зөрүүтэй тайлагнасан.	1	1,450.6			1	1,450.6	1	1,450.6		
Дүн	2	1,740.8			2	1,740.8	2	1,740.8		

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлан дахь насжилт өндөртэй авлагыг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	224.6			1	224.6				
Түрээсийн орлогоос орон нутгийн орлогод төвлөрүүлэх 40 хувийг төвлөрүүлээгүй.	1	2,069.4	1	2,069.4						
Төсвийн хөрөнгөөр албан хаагчдад хувцас худалдан авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	2,524.5	1	2,524.5						
Дүн	3	4,818.5	2	4,593.9	1	224.6				

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр албан хаагчдад хувцас /цэргийн/ худалдан авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	1,027.0			1	1,027.0				
Төсвийн хөрөнгөөр төрийн ажил үйлчилгээг олон нийтэд мэдээлэх зорилгоор видео, фото мэдээлэл бэлтгүүлэн, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	2,680.0			1	2,680.0				
Дүн	2	3,707.0			2	3,707.0				